Тендерийн урилга

Огноо: 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр

Зээл/Буцалтгүй тусламжийн дугаар ба нэр: L3895/ L3896-MON Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл

Гэрээний дугаар ба нэр: CW-6-1, Услалтын системийг шинэчлэн сайжруулах барилгын ажил Ногоон хашаа дэд төсөл (Улиастай, Завхан)

1. Монгол Улс нь Азийн хөгжлийн банк (АХБ)-аас Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төслийг санхүүжүүлэх зорилгоор энэхүү санхүүжилтийг хүлээн авсан бөгөөд уг хөрөнгөөр дээр дурдсан гэрээний төлбөрийг санхүүжүүлэх зорилготой болно. Тендер шалгаруулалт нь АХБ-ны эрх бүхий орны тендерт оролцогчдод нээлттэй байна.

2. Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам (“Захиалагч”) нь эрх бүхий тендерт оролцогчийг Завхан аймгийн Улиастай суман дахь Ногоон хашаа дэд төслийн услалтын системийг шинэчлэн сайжруулах барилгын ажил болон ойн зурвас байгуулах (“Ажил гэх”) ажлын барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх, дуусгах тухай битүүмжилсэн санал ирүүлэхийг урьж байна.

3. Нээлттэй өрсөлдөөнт дотоодын тендер шалгаруулалтыг АХБ-ны ***нэг үе шаттай: нэг дугтуйт*** горимын дагуу зохион байгуулах ба тендерийн баримт бичигт заасан эрх бүхий орны бүх тендерт оролцогчдод нээлттэй байна.

4. Энэхүү тендер шалгаруулалтад зөвхөн дор дурдсан чадварын үндсэн шаардлагыг хангасан эрх бүхий тендерт оролцогч оролцоно. Үүнд:

1) Сүүлийн 3 (2022, 2023, 2024) жилийн барилгын ажлын жилийн дундаж борлуулалтын хэмжээ 1,316,000,000.00 төгрөг,
2) Сүүлийн 3 (2022, 2023, 2024) жилд гүйцэтгэж дуусгасан ижил төстэй нэг гэрээт ажлын үнэлгээ нь 658,000,000.00 төгрөгөөс доошгүй байх
3) Санхүүгийн нөөц хөрөнгийн шаардлага:

А. Ганц оролцогч бол:

САН-3 маягтад заасан санхүүгийн нөөц хөрөнгө нь САН-4 маягтад дурдсан, одоо хэрэгжиж буй гэрээний үүргийн дүнг оруулаагүй хэмжээгээр 147,000,000.00 төгрөг бүхий энэхүү гэрээний нийт шаардлагыг хангах эсхүл давуулан хангах боломжтой эсэхийг тендерт оролцогч нотлон харуулах ёстой,

Б. Түншлэл бол:

(1) САН-3 маягтад заасан санхүүгийн нөөц хөрөнгө нь САН-4 маягтад дурдсан одоо хэрэгжиж буй гэрээний үүргийн дүнг оруулаагүй хэмжээгээр уг гэрээний нийт шаардлагын 40 хувийг хангах эсхүл давуулан хангах боломжтой эсэхийг нэг гишүүн нотлон харуулах ёстой МӨН

(2) САН-3 маягтад заасан санхүүгийн нөөц хөрөнгө нь САН-4 маягтад дурдсан одоо хэрэгжиж буй гэрээний үүргийн дүнг оруулаагүй хэмжээгээр уг гэрээний нийт шаардлагын 25 хувийг хангах эсхүл давуулан хангах боломжтой эсэхийг гишүүн бүр нотлон харуулах ёстой МӨН

(3) САН-3 маягтад заасан санхүүгийн нөөц хөрөнгө нь САН-4 маягтад дурдсан одоо хэрэгжиж буй гэрээний үүргийн дүнг оруулаагүй хэмжээгээр 147,000,000.00 төгрөг бүхий энэхүү гэрээний нийт

шаардлагыг хангах эсхүл давуулан хангах боломжтой эсэхийг түншлэл нотлон харуулах ёстой.

4) Ажил гүйцэтгэхэд шаардагдах тусгай зөвшөөрөл: "шаардлагатай" Тусгай зөвшөөрлийн ялгах дугаар ба нэр: Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 147 дугаар тушаалаар батлагдсан суурь нөхцөл, шаардлагатай дүйцнэ.

    1) БА2.2 Усны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил буюу түүнээс дээш ангилалд хамаарах тусгай зөвшөөрөл

5. Дэлгэрэнгүй мэдээлэл авах болон тендерийн баримт бичигтэй танилцах сонирхолтой эрх бүхий тендерт оролцогч нь дараах хаягаар хандана:

Байгууллагын нэр: Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл
Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө 18А/1, ХАА-н хоршоологчдын үндэсний холбооны байр, 5 давхар, 511 тоот
Цахим шуудан: vpia.procurement1@gmail.com
Утас:77113895

6. Монгол хэл дээр боловсруулсан тендерийн баримт бичгийг авах хүсэлтэй тендерт оролцогч нь дээр дурдсан хаягт хандан энэ тухай албан хүсэлт гаргаж, үл буцаан олгох нөхцөлөөр 50,000 төгрөгийн төлбөрийг хийнэ. Төлбөрийн нөхцөл нь банкны шилжүүлэг байна.

Дансны нэр: ХНҮБУХААТөсөл
Дансны дугаар: 100900011976
Банкны нэр: Төрийн сан банк

7. Тендерийг тендер хүлээн авах эцсийн хугацаа 2025 оны 11-р сарын 05-ны өдрийн 10:00 цагаас өмнө Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө 18А/1, Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны байр, 5 давхар, 511 тоотод тендерийн баримт бичигт шаардсан тендерийн баталгааны хамт ирүүлнэ. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусмагц тендерийг нэн даруй нээх ба тендерт оролцогчдын төлөөллийг өөрсдийнх нь хүсэлтээр байлцуулна.

8. Захиалагч нь тендерт оролцогчийн тендер бэлтгэх, хүргүүлэхтэй холбогдсон аливаа зардлыг хариуцахгүй.